БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
**БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ**

# БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН
# МАГАДЛАЛЫН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТ

2020 оны 04 дугаар сарын 30 өдөр

Дугаар 693/2020

Улаанбаатар-15171
Утас: 323022, 328097
Факс: .........................

| | |
|---|---|
| **Барилга, байгууламжийн байршил, нэр, зориулалт:** | Хэнтий аймгийн Батноров сумын нутаг дэвсгэрт баригдах "320 хүүхдийн сургуулийн өргөтгөлийн барилга"-ын ажлын зураг төсөл, төсөв.<br>**ШИФР: L&H/08/19** |
| **Хүчин чадал:** | **Блок-1 сургуулийн барилга:**<br>**Барилгын хэмжээ:** Тэнхлэгээрээ 30.6 м x 15.8 м,<br>**Давхрын тоо:** ± 0.00 түвшнээс дээш 3 давхар,<br>**Блок-2 урлаг, спорт заалны барилга:**<br>**Барилгын хэмжээ:** Тэнхлэгээрээ 36.0 м x 33.0 м,<br>**Давхрын тоо:** ± 0.00 түвшнээс дээш 3 давхар,<br>**Блок-3 хүзүүвчний барилга:**<br>**Барилгын хэмжээ:** Тэнхлэгээрээ 17.62 м x 4.0 м,<br>**Давхрын тоо:** ± 0.00 түвшнээс дээш 1 давхар,<br>**Барилгын ажлын нийт талбай:** S=4,005.0 $м^2$, |
| **Захиалагч:** | Хэнтий аймгийн Батноров сумын ЗДТГ |
| **Санхүүжилтийн эх үүсвэр:** | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар<br>Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль<br>**/хуулийн дугаар XII.1.1.222/** |
| **Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр:** | "Эл энд Эйч констракшн" ХХК |
| **Регистрийн дугаар:** | РД: 2780933 |
| **Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:** | 2024.08.28 |
| **Ажлын төрөл:** | 1.2.1 заалтын дагуу |
| **Зураг төсөл боловсруулах үндэслэл:** | |
| Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх, олгосон захирамж, дугаар огноо: | Хэнтий аймгийн Батноров сумын Засаг даргын 2019.06.07-ны өдрийн А/80 тоот захирамж |
| Архитектор төлөвлөлтийн даалгавар, баталсан албан тушаалтан, дугаар, огноо: | Хэнтий аймгийн Ерөнхий архитекторын 2020.01.22-ны өдөр баталсан 2020/14 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар |
| Зураг төсөл боловсруулах даалгавар, баталсан албан тушаалтан, дугаар, огноо: | Хэнтий аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2019.06.01-ний өдрийн 05/2019 дугаартай зураг төсөл боловсруулах даалгавар |
| Зураг төсөл боловсруулах гэрээ, баталсан албан тушаалтан, дугаар, огноо: | Хэнтий аймгийн Батноров сумын Засаг дарга, "Эл энд Эйч констракшн" ХХК-ийн захирал нарын хооронд 2019.06.15-ны өдөр баталсан 02 дугаартай зураг төсөл боловсруулах гэрээ |

| | |
|---|---|
| **Зөвшөөрөлцсөн байгууллагууд:** | |
| Хэнтий аймгийн Ерөнхий архитектор | Б.Гантөгс |
| Хэнтий аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга | Д.Баярхүү |
| Хэнтий аймгийн Онцгой байдлын газрын дарга, Дэд хурандаа | Н.Чанцал |

| | |
|---|---|
| Хэнтий аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуйн хяналтын улсын ахлах байцаагч | Б.Энхболор |
| Хэнтий аймгийн Батноров сумын Засаг дарга | Г.Тайванжаргал |
| "Өндөрхаан-Илч" ХХК-ийн захирал | Б.Булгантогтох |
| Хэнтий аймгийн "БЗӨБЦТС" ТӨХК-ийн ТҮАХ дэд захирал бөгөөд ерөнхий инженер | Г.Шүрэнчулуун |

**Техникийн нөхцөл олгогдсон байдал:**

| Техникийн нөхцөлүүд: | Олгосон байгууллага: | Дугаар, огноо: | Хүчинтэй байх хугацаа: |
|---|---|---|---|
| Халаалт, агаар сэлгэлт: | "Өндөрхаан-Илч" ХХК | № 03 2020.03.06 | 1 жил |
| Ус хангамж, ариутгах татуурга: | Хэнтий аймгийн Батноров сумын Засаг дарга | № 87 2020.03.16 | Албан тоот |
| Цахилгаан хангамж: | "БЗӨБЦТС" ТӨХК | № ХЭ 19/35 2019.07.09 | 2 жил |
| Холбоо дохиолол: | Хэнтий аймгийн Батноров сумын ЕБС | № 37 2020.03.11 | Албан тоот |

**Барилга, байгууламжийн зураг төслийн бүрэлдэхүүн:**

| Зураг төслийн иж бүрдэл: | Зураг төсөл гүйцэтгэсэн байгууллагын нэр: | Магадлал хийсэн экспертийн нэр: |
|---|---|---|
| Барилга архитектур: | "Эл энд Эйч констракшн" ХХК | Л.Чагнаа |
| Барилга бүтээц: | "Эл энд Эйч констракшн" ХХК | С.Цэмбэлдорж |
| Дулаан хангамж: | "Дөрвөн гүн" ХХК | П.Өлзийбат |
| Дотор цэвэр, бохир ус: | "Аксиом констракшн" ХХК | Д.Дагвасүрэн |
| Гадна ус хангамж ариутгах татуурга: | "Содон шийдэл" ХХК | Д.Дагвасүрэн |
| Цахилгаан хангамж: | "Итгэлийн хад" ХХК | Д.Амгалан |
| Дотор холбоо, дохиолол: | "Хангайн нар" ХХК | Ж.Наранцэцэг |
| Барилгын төсөв: | "Гандирс Од" ХХК | Т.Норовжав |
| Инженер геологи: | "Аварга Геопроект" ХХК /Архив/ № 043/19/ | Дүгнэлт баталгаажсан Ю.Энхсайхан |

**Нэгтгэсэн дүгнэлт:** /Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоол/

Барилга байгууламжийн техник-эдийн засгийн үзүүлэлт, зураг төслийн үндсэн төлөвлөлт, техникийн шийдлийн талаар тусгасан товч тодорхойлолт;

**Барилга, байгууламж баригдах газрын байгаль, цаг уурын ерөнхий өгөгдөл:**

Гадна агаарын хэм: - 32.2 °C
Цасны ачаалал: 50 кг/м$^2$
Салхины ачаалал: 35 кг/м$^2$
Газар хөдлөлийн балл: 6 балл,
Барилгын төрөл: 2
Галд тэсвэршилтийн зэрэг: II

**Барилгын суурь суух буурь хөрс:**

Судалгааны талбай нь инженер геологийн дунд зэргийн төвөгтэй нөхцөлтэй, цайвар шаргал өнгөтэй, бага чийгтэйгээс усаар ханасан сайрга агуулсан элсэн ул хөрстэй гэж тодорхойлсон байна.

- Улирлын хөлдөлтийн норматив гүн: 3.12 м,
- Овойлтгүй,
- Хөрсний ус 4.0-10.0 м-т илэрч 2.9-3.0 м-т тогтсон,
- Цэвдэг хөрс тохиолдоогүй,

- Газар шорооны ажлын зэрэг: II,
- Хувийн цахилгаан эсэргүүцэл:
  Чийг багатэй нөхцөлд 1800-2000 Ом.м,
  Усаар ханасан нөхцөлд 900-1000 Ом.м,

**Буурь хөрсний механик шинж чанарын үзүүлэлт:**
Зууралтын хүч: $C^{н}$=1 кПа,
Дотоод үрэлтийн өнцөг: $Ф^{н}$=37°,
Хэв гажилтын модуль: $E_{н}$=40 мПа,
Тооцооны эсэргүүцэл: $R_{0}$=500 кПа,

**Барилга, байгууламжийн төлөвлөлт:**
Барилга нь тэнхлэгээрээ 30.6 м х 15.8 м, 36.0 м х 33.0 м, 17.62 м х 4.0 м хэмжээтэй, 3 блок, зөв бус хэлбэртэй, ± 0.00 түвшнээс дээш 3 давхар, цутгамал төмөр бетон арагт бүтээцтэй байхаар төлөвлөгдсөн байна.
Гадна довжооны хэсэгт "Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн гарын авлага" /БД 31-101-04/, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орон зай, орчны зураг төсөл төлөвлөлт" /БД 31-112-11/-ийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж налуу зам төлөвлөсөн байна.

**Блок-1 /сургуулийн барилга/:**

**1-р давхарт:**
Гонх, шатны хонгил, хонгил, анги, туслах өрөө, эмчийн өрөө, өлгүүр, вестибюль, цахилгааны өрөө, техникийн өрөө, ариун цэврийн өрөөг,

**2-р давхарт:**
Шатны хонгил, хонгил, анги, туслах өрөө, рекреаци, агуулах, ариун цэврийн өрөөг,

**3-р давхарт:**
Шатны хонгил, хонгил, анги, туслах өрөө, рекреаци, агуулах, ариун цэврийн өрөөг тус тус төлөвлөсөн байна.

**Үндсэн бүтээц нь:**
**Суурь:** Цутгамал төмөр бетон баганан суурьтай,
**Даацын үндсэн бүтээц нь:** Цутгамал төмөр бетон арагт бүтээцтэй,
**Гадна хана:** 360 мм-ийн блокон хана, 120 мм-ийн хөөсөнцөр дулаалгатай, 120 мм-ийн тоосгон өрлөгтэй,
**Хучилт:** Цутгамал төмөр бетон хучилттай,
**Дээвэр:** Хавтгай дээвэртэй байхаар төлөвлөсөн байна.

**Халаалт, агаар сэлгэлт:**
Халаалтын системд доогуур түгээлттэй 2 хоолойт мухардмал эргэлттэй систем төлөвлөсөн байна.
Агаар сэлгэлтийн ердийн систем төлөвлөсөн байна.
Хашлага хийцийн дулаан дамжуулалтын коэффициент: $K_{гх}$=0.25 Вт/м²·С, $K_{ц}$=1.82 Вт/м²·С, $K_{ха}$=4.0 Вт/м²·С, $K_{ху}$=0.24 Вт/м²·С,
Дулааны ачаалал: $Q_{бүгд}$=224,900 Вт,

**Цэвэр, бохир ус:**
Барилгад ахуйн болон галын усны систем төлөвлөсөн

байна. Барилгаас гарах бохир усыг өөрийн урсгалаар зайлуулагдахаар төлөвлөсөн байна.

Цэвэр, бохир усны тооцоо: $q_{бүгд}$=5.5 $м^3$/хон, $q_{гал}$=2.5 л/с
$q_{ху}$ = 3.6 $м^3$/хон, $q_{хал}$= 1.9 $м^3$/хон, $q_{бох}$ = 5.5 $м^3$/хон

**Дотор гэрэлтүүлэг, хүчит тоноглол:**

Тус барилга нь цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааны II зэрэгт хамрагдах тул гүн газардуулсан нейтральтай хос кабель шугамаар тэжээхээр төлөвлөсөн байна.

Газардуулгын эсэргүүцэл 4 Ом-оос хэтрэхгүй байна.

Цахилгааны ачаалал:

Цахилгааны оролт 1: $P_т$=114 кВт, $I_т$=181.5 А,

Цахилгааны оролт 2: $P_т$=45 кВт, $I_т$=59 А,

Сүлжээний хүчдэл 380/220В байна.

**Дотор холбоо, дохиолол:**

Барилгын холбоо дохиоллын системд суурин телефон, кабелийн телевиз, интернет сүлжээ, галын дохиолол, хяналтын камер, зарлан мэдээлэх систем зэргийг тус тус төлөвлөсөн байна.

**Блок-2 /урлаг спорт заалны барилга/:**

**1-р давхарт:**

Гонх, шатны хонгил, хонгил, спорт заал, хэрэгсэл хадгалах өрөө, хооллох заал, халуун цех, бэлтгэл цех, аяга таваг, сав угаах өрөө, сав хадгалах өрөө, хүнсний агуулах, нарийн боовны цех, ногооны агуулах, дарга, нябо, хуурай агуулах, мах сүүний агуулах, аж ахуйн агуулах, ажилчдын хувцас солих өрөө, материал хүлээн авах өрөө, рекреаци, ажилчдын ариун цэврийн өрөөг,

**2-р давхарт:**

Шатны хонгил, хонгил, спорт заал, соёлын заал, тайз, техникийн өрөө, рекреаци, арын өрөөг,

**3-р давхарт:**

Шатны хонгил, хонгил, бэльтаж, спорт заал, соёлын заалыг тус тус төлөвлөсөн байна.

**Үндсэн бүтээц нь:**

**Суурь:** Цутгамал төмөр бетон баганан суурьтай,

**Даацын үндсэн бүтээц нь:** Цутгамал төмөр бетон арагт бүтээцтэй,

**Гадна хана:** 360 мм-ийн блокон хана, 120 мм-ийн хөөсөнцөр дулаалгатай, 120 мм-ийн тоосгон өрлөгтэй,

**Хучилт:** Цутгамал төмөр бетон хучилттай,

**Дээвэр:** Хавтгай дээвэртэй байхаар төлөвлөсөн байна.

**Халаалт, агаар сэлгэлт:**

Халаалтын системд доогуур түгээлттэй 2 хоолойт мухардмал эргэлттэй систем төлөвлөсөн байна.

Агаар сэлгэлтийн ердийн систем төлөвлөсөн байна.

Хашлага хийцийн дулаан дамжуулалтын коэффициент: $К_{гх}$=0.27 Вт/$м^2$ С, $К_ц$=2.27 Вт/$м^2$ С, $К_{ха}$=1.21 Вт/$м^2$ С, $К_{ху}$=0.154 Вт/$м^2$ С,

Дулааны ачаалал: $Q_{хал}$=415,681 Вт, $Q_{х.ус}$=67,722 Вт,

$Q_{бүгд}$=483,403 Вт,

**Цэвэр, бохир ус:**

Барилгад ахуйн болон галын усны систем төлөвлөсөн байна. Барилгаас гарах бохир усыг өөрийн урсгалаар зайлуулагдахаар төлөвлөсөн байна.

Цэвэр, бохир усны тооцоо: $q_{бүгд}$=37.44 $м^3$/хон,

$q_{ху}$ = 20.16 $м^3$/хон, $q_{хал}$= 17.28 $м^3$/хон, $q_{бох}$ = 37.44 $м^3$/хон

**Дотор гэрэлтүүлэг, хүчит төхөөрөмж:**

Тус барилга нь цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааны II зэрэгт хамрагдах тул гүн газардуулсан нейтральтай хос кабель шугамаар тэжээхээр төлөвлөсөн байна.

Газардуулгын эсэргүүцэл 4 Ом-оос хэтрэхгүй байна.

Цахилгааны ачаалал:

Цахилгааны оролт 1: $P_т$=111 кВт, $P_с$=159 кВт, $I_т$=200 А,

Цахилгааны оролт 2: $P_т$=104 кВт, $P_с$=149 кВт, $I_т$=187 А,

Сүлжээний хүчдэл 380/220В байна.

**Дотор холбоо, дохиолол:**

Барилгын холбоо дохиоллын системд суурин телефон, кабелийн телевиз, интернет сүлжээ, галын дохиолол, хяналтын камер, зарлан мэдээлэх систем зэргийг тус тус төлөвлөсөн байна.

**Блок-3 /хүзүүвчний барилга/:**

**2-р давхарт:**

Хонгил төлөвлөсөн байна.

**Үндсэн бүтээц нь:**

**Суурь:** Цутгамал төмөр бетон баганан суурьтай,

**Даацын үндсэн бүтээц нь:** Цутгамал төмөр бетон арагт бүтээцтэй,

**Гадна хана:** 360 мм-ийн блокон хана, 120 мм-ийн хөөсөнцөр дулаалгатай, 120 мм-ийн тоосгон өрлөгтэй,

**Хучилт:** Цутгамал төмөр бетон хучилттай,

**Дээвэр:** Хавтгай дээвэртэй байхаар төлөвлөсөн байна.

**Гадна инженерийн шугам сүлжээ:**

**Гадна дулаан:**

Гадна дулааны эх үүсвэрийг одоо байгаа ДХ-6 худгийг шинэчлэн сольж, 2Ф89х3.5 мм-ийн голчтой, 3.7 м урттай ган хоолойгоор 800х450 мм-ийн хөндлөн огтлолтой, үл нэвтрэх бетон сувагт угсрахаар төлөвлөсөн байна.

**Гадна ус хангамж, ариутгах татуурга:**

Барилгын ус хангамжийн эх үүсвэрийг Ф50 мм-ийн ган хоолойгоор угсрах ба ариутгах татуургын шугамыг Ф100 мм голчтой, 129.4 м урттай хуванцар хоолойгоор одоо бохир усны цооногт холбохоор төлөвлөсөн байна.

**Гадна цахилгаан:**

Олгогдсон техникийн нөхцөлийн дагуу 35/10 кВ-ын Батноров дэд станцын ячейк №7 сумын төвийн 10 кВ-ын ЦДАШ-ын тулгуур №7-г төмөр бетон завсрын тулгуураар сольж, хуурай салгуур суурьлуулан 15.0 м зайд реклоузер таслууртай тулгуур босгон төлөвлөж

| | |
|---|---|
| | буй 100 кВА чадалтай дэд станц хүртэл YJLY-23 3x70 мм$^2$ хөндлөн огтлолтой, 340.0 м кабель шугамаар тэжээхээр төлөвлөсөн байна.<br>**Гадна холбоо:**<br>Олгогдсон техникийн нөхцөлийн дагуу сумын төвийн холбооны байрнаас төлөвлөж буй барилга хүртэл Ф100 мм-ийн нэг яндант сувагчлал хийж 4 core-ийн 195.0 м шилэн кабель сүвлэн барилгад оруулж, төгсгөлийн төхөөрөмжид холбохоор төлөвлөсөн байна. |
| Зураг төслийн сонгосон шийдэл, магадлал хийх явцад экспертээс өгсөн нэмэлт, өөрчлөлтийн саналыг зураг төсөлд тусгасан эсэх; | **Чиглэл тус бүрийн орон тооны бус экспертийн саналыг зураг төсөлд тусгасан байдал:**<br>Экспертүүдийн өгсөн зөвлөмжийн дагуу зураг төсөлд засвар өөрчлөлтүүдийг хийсэн байна. |
| Эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан эсэх; | **Хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан байдал:**<br>Нутгийн удирдлагын ордоны барилга баригдсанаар төрийн албан хаагчдын ажлын байрны нөхцөлд дээшлэх, иргэд төрийн үйлчилгээг хүртээмжтэй авах нөхцөл бүрдэх юм. |

**Хэнтий аймгийн Батноров сум, "320 хүүхдийн сургуулийн барилга"-ын ажлын төсөвт өртгийн нэгдсэн товчоо:**

Барилга угсралтын ажлын

| № | Тодорхойлолт | Төсөвт өртөг /төг/ | Хүчин чадал | Нэгж өртөг /төг/ |
|---|---|---|---|---|
| 1 | а/. Барилга угсралтын ажил: | | | |
| ББ | Барилга: 30.6 м х 15.8 м, 36.0 м х 33.0 м, | 3,260,355,335.0 | 4,005.0 | 814,087.0 |
| ХАС | 17.62 м х 4.0 м хэмжээтэй, 3 блок, | 126,218,547.0 | 4,005.0 | 31,516.0 |
| ЦБУ | Давхрын тоо: Зоорьтой, 3 давхар, Талбайн хэмжээ: 4,005.0 м$^2$ | 34,902,653.0 | 4,005.0 | 8,715.0 |
| ДГ-ХТ | Суурь: Цутгамал төмөр бетон баганан | 233,978,702.0 | 4,005.0 | 58,423.0 |
| ХД | Үндсэн хийц: Цутгамал төмөр бетон арагт бүтээц Гадна хана: 360 мм блок, 150 мм хөөсөнцөр дулаалга, 120 мм тоосго Хучилт: Цутгамал төмөр бетон Дээвэр: Хавтгай дээвэртэй. | 86,364,235.0 | 4,005.0 | 21,564.0 |
| | **Хэсгийн дүн:** | **3,741,819,472.0** | **4,005.0** | **934,306.0** |
| 2 | б/.Гадна инженерийн шугам сүлжээний ажил: | | | |
| ГДГ | Гадна дулаан /м/: 2Ф89х3.5 мм ган хоолой, /800х450 мм/ | 13,569,191.0 | 11.0 | 1,233,562.8 |
| УХ | Ус хангамж /м/: Ф50 мм ган хоолой | 1,127,988.0 | 11.0 | 102,544.0 |
| АТ | Ариутгах татуурга /м/: хуванцар Ф100 мм | 19,261,004.0 | 128.0 | 150,477.0 |
| ГЦ | Гадна цахилгаан /м/: 0.4 кВ | 30,244,841.0 | 340.0 | 88,955.0 |
| | **Хэсгийн дүн:** | **64,203,024.0** | | |
| 3 | в/. Гадна тохижилт: | | | |
| ГТ | Авто зогсоол /м$^2$/: Бетон хучилттай | 39,100,000.0 | 922.0 | 42,408.0 |
| ГТ | Явган зам талбай /м$^2$/: Өнгөт хавтан | 44,059,931.0 | 1,315.6 | 33,490.0 |
| | **Хэсгийн дүн:** | **83,159,931.0** | | |
| 4 | г/. Тоног төхөөрөмж: | | | |
| ТТ | Дэд өртөө /ком/: 100 кВА | 60,468,749.0 | | |
| | **Хэсгийн дүн:** | **60,468,749.0** | | |
| 5 | д/. Зураг төслийн үнэ: | | | |
| ЗТ | Зураг төслийн үнэ: | 81,560,000.0 | | |
| ИГ | Инженер геологи: | 2,000,000.0 | | |
| | **Хэсгийн дүн:** | **83,560,000.0** | | |
| | **Төсөвт өртгийн нэгдсэн товчоо:** | | | |
| **БУ** | **Барилга угсралтын ажил:** | **3,741,819,472.0** | | |
| **ГШ** | **Гадна инженерийн шугам сүлжээ:** | **64,203,024.0** | | |
| **ГТ** | **Гадна тохижилт:** | **83,159,931.0** | | |
| **ТТ** | **Тоног төхөөрөмж:** | **60,468,749.0** | | |
| **ЗТ** | **Зураг төслийн үнэ:** | **83,560,000.0** | | |
| | **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | | **4,033,211,176.0** | |

| | |
|---|---|
| **Төсөв:** | Эксперт нь Хэнтий аймгийн Батноров сумын нутаг дэвсгэрт баригдах “320 хүүхдийн сургуулийн өргөтгөлийн барилга”-ын ажлын нийт төсөвт өртгийг **4,033,211,176.0** /дөрвөн тэрбум гучин гурван сая хоёр зуун арван нэгэн мянга нэг зуун далан зургаан/ төгрөгөөр хянасан байна. |

**“Барилгын тухай” Монгол Улсын хуулийн /шинэчилсэн найруулга 2016 он/ 38.1.2-т “барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсгийг боловсруулсан зохиогч тухайн зураг төслийг баталгаажуулан, мэргэжлийн хариуцлага хүлээх”, 38.1.3-т “зураг төсөл зохиох хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх”, 39.4-т “Эксперт барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргаж, мэргэжлийн хариуцлага хүлээх”, 39.5-д заасны дагуу “Экспертийн эрх бүхий хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотолж, техникийн шийдлийн талаарх дүгнэлт гаргаж, хариуцлага хүлээнэ”.**

Хэнтий аймгийн Батноров сумын нутаг дэвсгэрт баригдах “320 хүүхдийн сургуулийн өргөтгөлийн барилга”-ын ажлын зураг төсөл, төсөвт “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”, “Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм” /БНбД 81-94-12/, “Барилгын төсөв зохиох дүрэм” /БНбД 81-95-12/-ийг тус тус үндэслэн магадлал хийх ажлыг зохион байгуулж, нэгтгэсэн дүгнэлт бичсэн болно.

Нэгтгэсэн дүгнэлт нь экспертүүдийн **14** хуудас магадлалын дүгнэлтийн хамт хүчинтэй.

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД
МАГАДЛАЛ ХИЙХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН:

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ Ц.АМАРСАНАА

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА Э.ХАНГАЛ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Б.ЦОЛМОН-ОД

БАТЛАВ.
БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ ............. Ц.АМАРСАНАА

202.... оны .... сарын .... өдөр

БАТЛАВ.
ЗАХИАЛАГЧ: "Эл энд Эйч констракшн" ХХК-ИЙН ЗАХИРАЛ
............. С.ЧУЛУУН

202.... оны .... сарын .... өдөр

# ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧИГТ МАГАДЛАЛ ХИЙХ АЖЛЫН ГЭРЭЭ

Дугаар Е-0561/2020

***Нэг. Ерөнхий зүйл***

1.1. Монгол Улсын "Барилгын тухай" хууль, “Иргэний хууль”-ийн 343 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийг үндэслэн зураг төсөлд магадлал хийх ажлын хүрээнд захиалагч, гүйцэтгэгчтэй холбогдон гарах үүрэг, хариуцлагыг хангахад энэхүү гэрээний зорилго оршино.

1.2. Нэг талаас Барилгын хөгжлийн төвийг төлөөлж Магадлалын асуудал хариуцсан нэгжийн дарга (цаашид “гүйцэтгэгч” гэх) нөгөө талаас Магадлал хийлгэх хүсэлт гаргасан Зураг төслийн байгууллага, аж ахуй нэгж, иргэн (цаашид **"захиалагч"** гэх) түүнийг төлөөлж Захирал ажилтай Ч.Баярсайхан нар дараах зүйлийг харилцан тохирч энэхүү гэрээг байгуулав.

1.3. **Захиалагч** */Хөрөнгө оруулагч/* Хэнтий аймгийн Батноров сумын ЗДТГ
**Зураг төслийн гүйцэтгэгч:** "Эл энд Эйч констракшн" ХХК
**Обьектийн байрлал:** Хэнтий аймаг, Батноров сум, - баг
**Обьектийн нэр:** "320 сурагчтай сургуулийн өргөтгөлийн барилга"-ын ажлын зураг төсөл, төсөв
**Архив №:**
**Зураг төслийн гэрээний үнийн дүн:** 81,560,000 /төг/
*/Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар/*
**Магадлалын ажлын төлбөр:** 3,707,280.0 төг /гурван сая долоон зуун долоон мянга хоёр зуун наян төгрөг/
*/мөнгөн дүнг үсгээр, банкны төлбөрийн даалгаварт гэрээний дугаарыг бичсэн байна/*

1.4. Зураг төсөлд гүйцэтгэгч нь Барилгын тухай хуулийн 25.1-д заасныг үндэслэн хуанлийн 21 хоногт багтаан магадлал хийх ажлыг хамтран зохион байгуулахаар харилцан тохиролцов. Зураг төслийн баримт бичигт магадлал хийх ажлыг зохион байгуулах, магадлал хийлгэх **ажлын хөлсийг** захиалагч нь тус газрын **Голомт банк 1175107789** тоот дансанд гэрээний хугацаанд багтаан шилжүүлсэн байна.

***Хоёр. Гүйцэтгэгчийн эрх***

2.1. Барилгын хөгжлийн төвийн захирлын 2019 оны 19-р тушаалаар батлагдсан ”Барилга байгууламжийн ажлын зурагт тавигдах шаардлага, иж бүрдлийг хангуулах шалгах хуудас”-ны загварын дагуу захиалагчаас тухайн ажилд шаардагдах материал, холбогдох хууль эрх зүйн баримт бичгийг гаргуулж авах;

2.2. Шаардлага хангаагүй зураг төслийн баримт бичгийн бүрдлийг захиалагчид албан тоотоор хариу өгөх;

***Гурав. Гүйцэтгэгчийн үүрэг***

3.1. “Барилгын тухай” хуулийн 25.2, 25.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 6 дугаар зүйлийг үндэслэн магадлал хийлгэх ажлыг зохион байгуулах;

3.2. Зураг төслийн баримт бичигт магадлал хийх явцад ажлын шаардлагаар хүсэлтийн дагуу гэрээний хугацааг хоёр тал хамтран тохиролцсоны үндсэн дээр сунгах;

***Дөрөв. Захиалагчийн эрх***

4.1. Захиалагч орон тооны бус экспертийн гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд дахин эксперт томилуулах санал оруулах;

4.2. Томилогдсон тухайн эксперт магадлалын ажлыг гүйцэтгэх боломжгүй бол ажлын 1 хоногийн дотор мэдэгдэж экспертийг дахин томилуулах;

4.3. Гэрээнд заагдсан хугацаанд ажлыг гүйцэтгэх боломжгүй тохиолдолд хугацааг сунгах, үндэслэлийг гаргах;

***Тав. Захиалагчийн үүрэг***

5.1. Гэрээний хавсралт бүхий баримт бичгийн үнэн зөвийг хариуцах;

5.2. Магадлалын ажилд шаардагдах хууль эрх зүйн баримт бичиг, материалыг тухай бүр цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж өгөх;

5.3. Магадлалын дүгнэлтээр гарсан зарчмын санал, зөрчлийг барилга байгууламжийн зураг төслийг хянан нягталж, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хугацаанд багтаан залруулга, тодруулга тайлбарыг хийж гүйцэтгэсэн байх;

5.4. Энэхүү гэрээний 1.4-д заасан хугацаатай уялдуулан орон тооны бус экспертийн гаргасан дүгнэлтийн дагуу залруулга /засвар/-ыг 10 хоногт[1] багтаан хийж дуусган тус төвийн гэрээ хийсэн мэргэжилтэнд хүргүүлсэн байх;

***Зургаа. Хүлээх хариуцлага***

6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадаагүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргаж асуудлыг шийдвэрлүүлнэ;

6.2. Зураг төслийн баримт бичигт магадлал хийх явцад ажлын шаардлагаар гэрээ сунгавал тухай бүр тэмдэглэл хөтөлж, гэрээний биелэлтийг дүгнэж сунгах эсэх асуудлыг шийдвэрлэж байна.

6.3. Зураг төсөл магадлалын ажил гүйцэтгэх явцад энэхүү гэрээний 5.4-т заасан хугацааг хэтрүүлсэн бол хугацаа хэтэрсэн хоног тутамд зураг төслийн магадлалын ажлын төлбөрийн дүнгийн 0.4 хувиар алдангийг тооцно.

6.4. Зураг төслийн баримт бичигт магадлал хийх хугацаанд байгалийн давагдашгүй хүчин зүйлд өртсөн нөхцөлд зайлшгүй нотлох баримтыг үндэслэн хоёр тал харилцан тохиролцож асуудлыг шийдвэрлэнэ.

6.5. Энэхүү гэрээнд Монгол Улсын хуулийг дагаж мөрдөх ба гэрээний хэл нь "Монгол хэл" байна.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Гүйцэтгэгчийг төлөөлж:

Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга ............................ /Т.НЯМДАВАА/ 29/12/2020

Барилга байгууламжийн зураг төсөл магадлалын хэлтсийн дарга ............................ /Э.ХАНГАЛ/

Утас: 70115255

Барилга байгууламжийн зураг төсөл магадлалын хэлтсийн мэргэжилтэн ............................ /Б.ЦОЛМОН-ОД/

Захиалагчийг төлөөлж:
Зураг төслийн байгууллага:

Захирал ............................ /Ч.БАЯРСАЙХАН/

Захиалагчийн утас:98962929
Гүйцэтгэгчийн утас:90111595